

1. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Захиалагч нь: “ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК
Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: “Уран сайхны кино, баримтат болон олон ангит кино бүтээх” ЭТТ/202001077-3
Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: Гэрээ байгуулснаас хойш Багц 1 - 180 хоног Багц 2 - 210 хоног
Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 2 багцтай Багц 1 Уран сайхны кино Багц 2 Олон ангит кино
Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгөөр Төсөвт өртөг: Багц 1 – 800,000,000 /Найман зуун сая/ төгрөг Багц 2 – 500,000,000/Таван зуун сая/ төгрөг
ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага: 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар гэрчлүүлэн/ 2. Байгууллагын танилцуулга 3. Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт /Үнийн санал ирүүлэх өдрөөр хүчинтэй байх/ 4. ШШГЕГ-ын тодорхойлолт /Үнийн санал ирүүлэх өдрөөр хүчинтэй байх/ 5. Татварын цахим тодорхойлолт /Үнийн санал ирүүлэх өдрөөр хүчинтэй байх/ 6. 2018, 2019 онуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт 7. Сүүлийн 5 жилд /2015-2019/ 1 ангит уран сайхны болон 10 ба түүнээс олон ангит кино 1-ээс доошгүйг бүтээж, телевизийн сувгаар дамжуулан олны хүртээл болгосон байх /киноны постер болон трейлерийг ирүүлэх/ 8. Сүүлийн 2 жилийн /2018, 2019 оны/ борлуулалтын орлогын дундаж нь тухайн багцын төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх
2. ТЕХНИКИЙН БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ ШААРДЛАГА
Тоног төхөөрөмжийн шаардлага: Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж: Дүрсний чанар: - RED болон түүнтэй дүйцэхүйц, 4K resolution-оос дээш үзүүлэлттэй, кино зураг авалтын хоёроос доошгүй мэргэжлийн камертай байх / зураг танилцуулга ирүүлэх/ - 4K resolution-оос дээш /4096 x 2160 pixels/; Өнгөний зохицолтой байх; Дууны чанар: - Dolby digital 5.1 surround sound сувгаар бичих; - Хамгийн багадаа 192kbps нягтралтай, 48kHz sample rate давтамжтай Гүйцэтгэгч нь кино бүтээх ажлыг гүйцэтгэх явцад хэрэглэх өөрийн эзэмшлийн эсхүл түрээсийн техник, тоног төхөөрөмж /мэргэжлийн дрон, кран, гүйдэг зам, чичиргээ дарагч, гэрэл, микрофон гэх мэт/, авто машинтай байна.

Кино багийн уран бүтээлчдийн туршлага, танилцуулгыг ирүүлэх:

Багц 1, Багц 2-т заасан киноны уран бүтээлч, голлох мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байна.

№	Уран бүтээлчид	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Нотлох баримт
1	Зохиолч	1	5-аас дээш	Уран сайхны болон олон ангит киноны жагсаалт /киноны нэр, огноо, оролцсон үүрэг/
2	Ерөнхий найруулагч	1	5-аас дээш	
3	Ерөнхий зураглаач	1	5-аас дээш	

- Дээрх уран бүтээлчдийн мэргэжлийн сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар зэргийг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.
- Ерөнхий найруулагч, ерөнхий зураглаач нь тухайн хуулийн этгээдийн үндсэн ажилтан, үндсэн ажилтан биш бол хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан байна.

Тендерт түншлэлээр оролцож болно.

Тендерийн баримт бичгийн хэл нь Монгол хэл байна.

Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ:

1. Багц 1, багц 2-т заасан уран сайхны болон олон ангит кино хийсэн туршлагыг жагсаалтаар ирүүлэх бөгөөд магадлах зорилгоор постер болон трейлерийг тус тус тендерийн хамт ирүүлнэ.
2. Зураг авалтын студи, павильонтой байх, /өөрийн бол холбогдох баримт бичиг, түрээсэлдэг бол түрээсийн гэрээг хавсаргаж ирүүлэх/
3. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлгийг ирүүлнэ.
4. Техникийн тодорхойлолтод дурдсан жанр, агуулгын дагуу киноны дүр, гол үйл явдлуудыг тусгасан хураангуй зохиол буюу синопсисыг хоёроос илүүгүй хуудсанд багтаан бичиж тендерийн хамт ирүүлэх /багц 1, багц 2-д хамаарна./
5. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь ирүүлнэ.

Тендерийн валют: Төгрөг байна.

Тендерийн баталгааны үнийн дүн:

Багц 1 –ийн тендерийн баталгааны дүн: 8,000,000 төгрөг

Багц 2-ийн тендерийн баталгааны дүн: 5,000,000 төгрөг

Хүчинтэй байх хугацаа: 2020 он 11 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал

Багц 1, багц 2-т Гүйцэтгэлийн баталгаа шаардлагатай.

Тохирох маягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгө дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү байна.

3. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАГЦ 1: УРАН САЙХНЫ КИНОНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Уран сайхны киноны төрөл, агуулга	- Монгол Улсын хөгжлийн асуудлууд, өнөөгийн нийгмийн дүр төрх, ирээдүй хойч үед түүх, соёл, байгаль эх дэлхийгээ хайрлах үзлийг түгээх, өвлүүлэн үлдээх талаар асуудал дэвшүүлсэн, сургамж бүхий агуулгыг уран сайхны аргаар илэрхийлэх - “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхай, оффис, лого зэргийг киноны зурганд оруулах. (Өмнө нь тендерт ирүүлсэн зохиолыг дахин ирүүлсэн тохиолдолд үнэлэхээс татгалзана.)
Эхлэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс
Дуусах хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 180 хоног
Ажил гүйцэтгэх үе шат	Киноны үе шат 3 хэсэгт хуваагдана. 1 дэх үе шат Зохиол бичиж, жүжигчид сонгох Нийт ажлын 30% байх ба гүйцэтгэх хугацаа 30 - 40 хоног 2 дахь үе шат Зураг авалт хийх Нийт ажлын 40% байх ба гүйцэтгэх хугацаа 90 - 100 хоног 3 дахь үе шат Монтаж хийгээд хүлээлгэн өгөх Нийт ажлын 30% байх ба гүйцэтгэх хугацаа 30 - 40 хоног
Ажлын хамрах хүрээ	- Техникийн тодорхойлолтод дурдсан жанр, агуулгын дагуу киноны дүр, гол үйл явдлуудыг тусгасан хураангуй зохиол буюу синопсисыг хоёроос илүүгүй хуудсанд багтаан бичиж тендерийн хамт ирүүлэх - Зохиолын дагуу дүр бүтээх жүжигчдийг захиалагчид танилцуулж, санал авах; - Киноны зураг авалт хийх газрын байрлалыг тодорхойлж, хуваарийг захиалагчаар батлуулах; - Кино нь хамгийн багадаа нэг дуутай байх; - Зохиол, батлагдсан хуваарийн дагуу орчин үеийн дэвшилтэт технологиудыг ашиглан, дүрс, дууны өндөр чанартай иж бүрэн уран сайхны кино хийж компанид хүлээлгэн өгөх; - Тендерийн хамт ирүүлсэн маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөний дагуу киног бүтээх явцад олон нийтийн анхаарал, сонирхлыг татах маркетинг, сурталчилгааг хийж эхлэх;
Уран сайхны киноны жанр	- Драм
Уран сайхны кино үргэлжлэх хугацаа	90-120 минут
Техникийн шаардлага болон гүйцэтгэгчид тавигдах бусад шаардлага	<u>Дүрсний чанар:</u> - 4K resolution-оос дээш /4096 x 2160 pixels/; - Өнгөний зохицолтой байх; <u>Дууны чанар:</u> - Dolby digital 5.1 surround sound сувгаар бичих; - Хамгийн багадаа 192kbps нягтралтай, 48kHz sample rate давтамжтай;

	- RED болон түүнтэй дүйцэхүйц, 4K resolution-оос дээш үзүүлэлттэй, кино зураг авалтын хоёроос доошгүй мэргэжлийн камертай байх; - Уран сайхны киног олон нийтэд сурталчлах маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг оролцуулсан нийт ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, хугацаат хуваарь; - Маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөнд сошиал орчин, телевизийн суваг болон бусад бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр хийх сурталчилгааны календарьчилсан төлөвлөгөөг ирүүлнэ. Ингэхдээ дараах мэдээллүүдийг нарийвчлан тусгах ба сурталчилгааны бусад арга хэлбэрүүдийг нэмж тусгаж болно. - Хэрэв тухайн хуулийн этгээд нь маркетинг, сурталчилгааны чиглэлээр аливаа байгууллагатай гэрээтэй бол гэрээг хавсаргана. - Киноны борлуулалтаас олох эдийн засгийн тооцооллыг ирүүлэх,
бусад	- Кино болон түүнтэй холбогдон гарсан бүх зүйл компанийн өмчлөлд шилжиж, оюуны өмчөөр хамгаалагдана.

БАГЦ 2: ОЛОН АНГИТ КИНОНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Олон ангит кино бүтээх зорилго, үндэслэл	- “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 10 жилийн ойг тохиолдуулан компанийн үйл ажиллагаа, улсын нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр, уурхайчдын ажил, амьдралыг олон ангит киногоор дамжуулан уран сайхны аргаар үзүүлэх. - Олон ангит киногоор дамжуулан олон нийтэд 1072 хувьцааны талаар мэдээлэл өгөх. (Өмнө нь тендерт ирүүлсэн зохиолыг дахин ирүүлсэн тохиолдолд үнэлэхээс татгалзана.)
Эхлэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс
Дуусах хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 210 хоног
Ажил гүйцэтгэх үе шат	Киноны үе шат 3 хэсэгт хуваагдана. 1 дэх үе шат Зохиол бичиж, жүжигчид сонгох Нийт ажлын 30% байх ба гүйцэтгэх хугацаа 30 - 40 хоног 2 дахь үе шат Зураг авалт хийх Нийт ажлын 40% байх ба гүйцэтгэх хугацаа 100- 120 хоног 3 дахь үе шат Монтаж хийгээд хүлээлгэн өгөх Нийт ажлын 30% байх ба гүйцэтгэх хугацаа 40 - 50 хоног
Ажлын хамрах хүрээ	- Техникийн тодорхойлолтод дурдсан жанр, агуулгын дагуу киноны дүр, гол үйл явдлуудыг тусгасан хураангуй зохиол буюу синопсисыг хоёроос илүүгүй хуудсанд багтаан бичиж тендерийн хамт ирүүлэх - Зохиолын дагуу дүр бүтээх жүжигчдийг захиалагчид танилцуулж, санал авах - Киноны зураг авалт хийх газрын байрлалыг тодорхойлж, боловсруулсан хуваарийг - Кино нь хамгийн багадаа нэг дуутай байх; - Зохиол, батлагдсан хуваарийн дагуу орчин үеийн дэвшилтэт технологиудыг ашиглан, дүрс, дууны өндөр чанартай иж бүрэн олон ангит уран сайхны кино хийж компанид хүлээлгэн өгөх; - Тендерийн хамт ирүүлэх маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөний дагуу киног бүтээх явцад олон нийтийн анхаарал, сонирхлыг татах маркетинг, сурталчилгааг хийж эхлэх.
Олон ангит киноны жанр	Драм
Олон ангит киноны төрөл, агуулга	- Уул уурхайн салбарын улсын эдийн засагт үзүүлж буй нөлөөг харуулах; - Уурхайчдын ажил, амьдралыг харуулах; - “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн түүхэн хөгжлийн онцлогуудаас тусгах; - Цаг хугацааны хувьд түүхэн үйл явдлуудтай уялдаатай байх; - Ирээдүй, хойчид хүртээмжтэй байхын тулд ямар салбар, бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийж болох санал, сэдэл өгөх; - “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхай, оффис, лого зэргийг киноны зурганд оруулах;

	- Киноны зарим дүрд компанийн ажилтнуудаас оролцуулах.
Олон ангит киноны хэмжээ	10-аас доошгүй ангитай. Анги тус бүр нь 40-50 минут.
Техникийн шаардлага болон гүйцэтгэгчид тавигдах бусад шаардлага	<u>Дүрсний чанар:</u> - 4K resolution-оос дээш /4096x2160 pixels/. - Өнгөний зохицолтой байх <u>Дууны чанар:</u> - Dolby digital 5.1 surround sound сувгаар бичих; - Хамгийн багадаа 192kbps нягтралтай, 48kHz sample rate давтамжтай; - RED болон түүнтэй дүйцэхүйц, 4K resolution-оос дээш үзүүлэлттэй, кино зураг авалтын хоёроос доошгүй мэргэжлийн камертай байх /зураг, танилцуулга ирүүлэх/ - Олон ангит киног олон нийтэд сурталчлах маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг оролцуулсан нийт ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, хугацаат хуваарь; - Маркетингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөнд сошиал орчин, телевизийн суваг болон бусад бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр хийх сурталчилгааны календарчилсан төлөвлөгөөг ирүүлнэ. Ингэхдээ дараах мэдээллүүдийг нарийвчлан тусгах ба сурталчилгааны бусад арга хэлбэрүүдийг нэмж тусгаж болно. - Хэрэв тухайн хуулийн этгээд нь маркетинг, сурталчилгааны чиглэлээр аливаа байгууллага, телевизтэй гэрээтэй бол гэрээг хавсаргана. - Киноны борлуулалтаас олох эдийн засгийн тооцооллыг ирүүлэх /Телевизийн сувгийн реклам, олон ангит киног видео санд байршуулах зэргээс олсон ашгийг тооцоолох/.
бусад	- Кино болон түүнтэй холбогдон гарсан бүх зүйл компанийн өмчлөлд шилжиж, оюуны өмчөөр хамгаалагдана.